



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг.  
Их ээзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2018. 03. 06 № 19

Асуулга тавих тухай

Манай улсын эдийн засгийн хамгийн гол тулгуур болсон мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр чамгүй олон хууль, бодлого хөтөлбөр батлагдсан билээ. Тухайлбал үүнд "Монгол мал" үндэсний хөтөлбөр, Малчдын талаар төрөөс баримтлах бодлого, Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль зэргийг дурдаж болно.

Сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо толгой эрс ёсч 2017 оны байдлаар 66,2 саяд хүрээд байна. Гэсэн хэдий ч 200 гаруй мянган малчин өрхийн амьжиргаа болсон малын тоо толгой нь ёссөнөөс ашиг шим нь төдийлөн нэмэгдсэнгүй.

Малын зүй бус хорогдол 2018 оны 03 дугаар сарын 01-ний байдлаар улсын хэмжээнд 694.0 мянга боллоо. Мөн 03-р сарын 05-ны байдлаар 12 аймгийн 33 суманд шүлхий өвчин гараад байна. Хэдийгээр цаг наашилж байгаа ч цаашдаа хаваржилт хүндэрч, малын хорогдол нэмэгдэж, мал төллөлтөд хүндрэл учирч болзошгүй байна.

Дундардаг биш ундардаг, дуусдаг биш үрждэг, хамгийн олон ажлын байр бий болгож буй мал аж ахуйн салбараа хөгжүүлэх, малчдын амьжиргааг дээшлүүлэхийн тулд тэдний орлогын гол эх үүсвэр болсон малын үүлдэр угсааг сайжруулах, мал эрүүлжүүлэх ажлыг орон даяар эрчимтэй зохион байгуулах, малын түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих нь ихээхэн чухал юм.

Тиймээс "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" болон Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрт туссан мал аж ахуйн салбарын талаар баримтлах бодлого зорилт, төрөөс гаргасан зарим хууль, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хаваржилт хүндэрч буй аймаг сумдын малчдад цаг алдалгүй туслах шаардлагатай байна.

Иймээс Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар эүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд танд хандан тавьж байна. Үүнд:

1. "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ийн хөдөө аж ахуйн салбарын зорилтын 1-р үе шат буюу 2016-2020 онд хэрэгжүүлэхээр тусгасан "...Үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох" зорилтын хэрэгжилт хэрхэн хангагдаж байна вэ? Мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт ямар байгаа талаар
2. Монгол Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрт туссан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын явц байдал. Мөн хөтөлбөрт туссан "Малжуулах" төслийг хэзээнээс хэрхэн хэрэгжүүлж эхлэх тухай. Мал эрүүлжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, ашиг шимиийг нь нэмэгдүүлэх талаар ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?
3. Малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад учирч буй хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангах зорилтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа
4. Малын зүй бус хорогдолоос урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, түүний үр дүн, хаваржилт, мал төллөлтийн өнөөгийн нөхцөл байдал, хэчнээн төл хүлээн авах урьдчилсан тооцоог
5. Засгийн газраас батласан "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрт туссан малын гаралтай түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр ойрын хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын талаар тодорхой хариултыг боловсруулж ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ

Л.ЭНХ-АМГАЛАН